

2015 оны эхний 9 дүгээр сард Цагдаагийн байгууллагад


ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээ

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2015 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас 7243 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 512 нэгж буюу 7.6 хувиар өссөн байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 314 буюу 4.4 хувь нь санал, 6804 буюу 93.9 хувь нь өргөдөл, 125 буюу 1.7 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



Өргөдөл, гомдлыг
утгаар нь авч үзвэл: 1050 буюу 14.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 253 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1277 буюу 17.6 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1887 буюу 26.1 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 359 буюу 5.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 2417 буюу 33.4 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 7197 буюу 99.3 хувийг шийдвэрлэж, 46 өргөдлийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2015 оны эхний 9 сард Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 724 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 157 нэгж буюу 27.7 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 663 буюу 91.6 хувь нь өргөдөл, 61 буюу 8.4 хувь нь гомдол байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 64 буюу 8.8 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 75 буюу 10.4 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 136 буюу 18.8 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 16 буюу 2.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 85 буюу 11.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 348 буюу 48.1 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төв ирсэн өргөдөл, гомдол, шүүмлэл, санал хүсэлтийн талаар

2015 оны эхний 9 сарын байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 233 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 110 буюу 47.2 хувь нь санал хүсэлт, 91 буюу 39.5 хувь нь гомдол, 17 буюу 7.2 хувь нь талархал, 13 буюу 5.6 хувь нь шүүмжлэл, 2 буюу 0.9 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 210 буюу 90.1 хувийг шийдвэрлэж, 23 буюу 9.9 хувь нь ажиллагаанд байна.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2015 оны эхний 9 сард иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1210 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 296 нэгж буюу 24.5 хувиар өсч, 1300 алба хаагч холбогдсоны 717 буюу 74.9 хувь нь офицер, 313 буюу 24.1 хувь нь ахлагч, 13 буюу 1.0 хувь нь энгийн алба хаагчид байна. Нийт өргөдөл гомдлын 1204 буюу 99.5 хувийг барагдуулж, 55 буюу 6.0 хувийн үлдэгдэлтэй байна.

